



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/163/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

№ 2167 № 2021.02.25

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Номундалай” цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Номундалай” цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0050?0377

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>199,611,940.95</u>	<u>240,780,067.83</u>
33	АВЛАГА	14,175,548.88	1,132,783.57
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,346,102.28	25,460.55
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	1,000,000.00
335	Бусад авлага	12,829,446.60	107,323.02
3351	Байгууллагаас авах авлага	12,538,737.80	107,323.02
3352	Хувь хүмүүсээс авах авлага	290,708.80	00.00
34	УРЬДЧИЛГАА	2,748.00	2,748.00
3471	Урьдчилгаа тооцоо	2,748.00	2,748.00
34713	Цалингийн урьдчилгаа	2,748.00	2,748.00
35	БАРАА МАТЕРИАЛ	185,433,644.07	239,644,536.26
351	Түүхий эд материал	7,148,940.00	15,451,098.00
35130	Эм боох материал	7,148,940.00	15,451,098.00
354	Хангамжийн материал	172,810,704.07	218,719,438.26
35410	Бичиг хэргийн материал	2,761,150.00	1,655,000.00
35420	Аж ахуйн материал	6,597,449.99	16,109,692.49
35440	Түлш, шатах тослох материал	3,510,424.00	853,383.28
35450	Барилгын засварын материал	7,724,765.00	9,666,762.01
35460	Хүнсний материал	154,580.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	152,062,335.08	190,434,600.48
35600	Мал амьтад	5,474,000.00	5,474,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,374,913,340.27</u>	<u>10,845,944,720.19</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,374,913,340.27	10,845,944,720.19
392	Биет хөрөнгө	1,489,441,673.57	9,953,941,053.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,444,833,378.00	10,105,692,267.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-324,452,858.26	-552,915,392.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	528,132,059.54	584,501,689.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-387,912,908.03	-413,606,416.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	367,815,200.79	375,158,446.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-176,903,806.67	-183,990,148.86
39217	Ном	37,930,608.20	39,100,608.20
393	Биет бус хөрөнгө	885,471,666.70	892,003,666.74
39301	Програм хангамж	5,865,000.00	13,715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,688,333.30	-3,006,333.26
39303	Бусад биет бус хөрөнгө	881,295,000.00	881,295,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,574,525,281.22</u>	<u>11,086,724,788.02</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>319,364.28</u>	<u>1,716,409.26</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	319,364.28	1,716,409.26
413	Өглөг	319,364.28	1,716,409.26
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.30
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	179,702.28	1,576,796.96
4136	Бусад өглөг	139,662.00	139,612.00
41361	Байгууллагад төлөх өглөг	50.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	139,612.00	139,612.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,574,205,916.94	11,085,008,378.76
51	Засгийн газрын хувь оролцоо	2,574,205,916.94	11,085,008,378.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		2,483,997,027.68	2,483,997,027.68
51101	Өмч: - төрийн	2,483,997,027.68	2,483,997,027.68
512	Хуримтлагдсан үр дүн	-1,509,975,822.30	7,000,826,639.52
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,509,975,822.30	-1,509,975,822.30
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	8,510,802,461.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,600,184,711.56	1,600,184,711.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,574,525,281.22	11,086,724,788.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,301,580,983.12	12,912,603,910.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	306,115,967.12	8,686,373,774.38
120	Нийтлэг татварын бус орлого	306,115,967.12	8,686,373,774.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	306,115,967.12	10,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,000,000.00	10,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	295,115,967.12	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/	00.00	8,667,832,065.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/		8541709.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,995,465,016.00	4,037,700,316.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,281,489,800.00	3,323,725,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,281,489,800.00	3,323,725,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,567,716.00	183,528,744.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,820,816.00	128,382,353.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,746,900.00	55,146,391.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	582,407,500.00	718,976,292.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	582,407,500.00	718,976,292.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,185,520,666.12	4,401,751,448.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,185,520,666.12	4,401,751,448.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,937,242,857.37	4,212,651,185.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,630,831,918.00	2,698,766,065.00
210101	Үндсэн цалин	2,309,904,446.00	2,698,766,065.00
210102	Нэмэгдэл	88,969,052.00	00.00
210104	Урамшуулал	231,958,420.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,746,531.58	349,135,495.82
210201	Тэтгэврийн даатгал	224,565,146.58	244,803,571.37
210202	Тэтгэмжийн даатгал	26,507,269.00	26,955,530.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,167,745.00	21,574,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,955,126.00	5,062,209.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,551,245.00	50,739,685.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	555,674,592.95	699,843,088.96
210301	Гэрэл, цахилгаан	17,418,330.95	24,304,146.96
210302	Түлш, халаалт	455,723,670.00	600,913,150.00
210303	Цэвэр, бохир ус	82,532,592.00	74,625,792.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,529,381.80	36,669,528.40
210401	Бичиг хэрэг	9,540,135.00	7,922,450.00
210402	Тээвэр, шатахуун	2,953,549.00	6,010,327.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,193,489.50	2,385,739.50
210404	Ном, хэвлэл	00.00	1,215,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,656,120.00	1,398,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,186,088.30	17,738,011.80

2105	Нормативт зардал	46,815,712.00	36,495,895.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,567,260.00	1,641,060.00
210502	Хоол, хүнс	30,915,152.00	30,509,370.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,333,300.00	4,345,465.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,450,840.00	46,017,584.99
210604	Урсгал засвар	30,450,840.00	46,017,584.99
2107	Томилолт, зочны зардал	3,574,000.00	72,000.00
210702	Дотоод албан томилолт	3,574,000.00	72,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,553,300.00	21,390,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,953,300.00	20,790,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	284,066,581.04	324,260,676.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	759,350.00	22,965,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,941,681.73	3,981,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	206,365,549.31	297,314,176.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248,277,808.75	189,100,263.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	157,559,178.23	186,141,675.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	56,268,362.23	55,022,850.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,110,544.00	128,382,353.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	67,710,272.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,470,000.00	2,736,472.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,732,907.05	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,732,907.05	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,985,723.47	2,958,588.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,985,723.47	2,958,588.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	116,060,317.00	8,510,852,461.82
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10.00	50,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10.00	50,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10.00	-50,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	116,060,307.00	8,510,802,461.82

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,006,654,016.00	4,237,130,136.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,000,000.00	10,850,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,000,000.00	10,850,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,000,000.00	10,850,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,000,000.00	10,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	850,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,995,654,016.00	4,226,280,136.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,281,489,800.00	3,323,725,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,756,716.00	183,578,744.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,820,816.00	128,382,353.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,935,900.00	55,196,391.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	582,407,500.00	718,976,292.00

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	582,407,500.00	718,976,292.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,949,908,616.00	4,146,516,645.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,949,908,616.00	4,146,516,645.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,702,794,547.48	3,960,859,146.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,632,296,663.53	2,690,635,636.99
210101	Үндсэн цалин	1,514,415,988.53	1,723,049,992.00
210102	Нэмэгдэл	854,882,845.81	818,645,964.99
210104	Урамшуулал	262,997,829.19	148,939,680.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	329,048,500.00	354,601,400.00
210201	Тэтгэврийн даатгал	223,753,000.00	262,579,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	26,323,800.00	22,694,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,059,100.00	18,383,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,264,800.00	4,626,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,647,800.00	46,318,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	555,674,592.95	697,976,292.00
210301	Гэрэл, цахилгаан	17,418,330.95	22,437,400.00
210302	Түлш, халаалт	455,723,670.00	600,913,100.00
210303	Цэвэр, бохир ус	82,532,592.00	74,625,792.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,610,549.00	27,685,342.50
210401	Бичиг хэрэг	5,857,700.00	3,627,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,357,800.00	3,049,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,339,229.00	1,500,000.00
210404	Ном, хэвлэл	1,096,000.00	2,028,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, эрмэлтэй	3,656,120.00	1,398,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,303,700.00	16,082,642.50
2105	Нормативт зардал	60,569,772.00	58,253,093.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,284,700.00	1,480,208.00
210502	Хоол, хүнс	30,121,522.00	33,901,365.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,163,550.00	22,871,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,053,960.00	46,204,672.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,469,200.00	00.00
210602	Тавилга	7,650,000.00	00.00
210604	Урсгал засвар	11,934,760.00	46,204,672.00
2107	Томилолт, зочны зардал	3,574,000.00	72,000.00
210702	Дотоод албан томилолт	3,574,000.00	72,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,307,500.00	26,845,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,707,500.00	26,005,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,659,010.00	58,585,510.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,166,300.00	38,830,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,492,710.00	19,755,510.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	247,114,068.52	185,657,498.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	156,395,438.00	182,698,910.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,354,622.00	51,652,975.00
213207	Тэтгэмж Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	30,110,544.00	128,382,353.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	67,710,272.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,220,000.00	2,663,582.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,732,907.05	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,732,907.05	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,985,723.47	2,958,588.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,985,723.47	2,958,588.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	56,745,400.00	90,613,491.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	56,745,400.00	90,613,491.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,745,400.00	90,613,491.00
2200	Дотоод эх үүсвэрээр	56,745,400.00	90,613,491.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,264,054,795.77	1,121,541,355.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,264,054,795.77	1,121,541,355.91
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-143,044,864.93	-143,044,864.93
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,600,184,711.56	-1,509,975,822.30	2,574,205,916.94
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,600,184,711.56	-1,509,975,822.30	2,574,205,916.94
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,483,997,027.68	1,600,184,711.56	-1,509,975,822.30	2,574,205,916.94
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,510,802,461.82	8,510,802,461.82
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,600,184,711.56	7,000,826,639.52	11,085,008,378.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,052,701,400.00	4,049,742,803.49	2,958,596.5	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,052,701,400.00	4,049,742,803.49	2,958,596.5	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,996,030,200.00	3,995,426,246.49	603,953.5	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,690,636,300.00	2,690,635,636.99	663.0	100.0
210101	Үндсэн цалин	1,723,050,000.00	1,723,049,992.00	8.0	100.0
210102	Нэмэгдэл	818,646,600.00	818,645,964.99	635.0	100.0
210104	Урамшуулал	148,939,700.00	148,939,680.00	20.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	354,601,400.00	354,601,400.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	261,845,800.00	262,579,300.00	-733,500.0	100.3
210202	Тэтгэмжийн даатгал	23,188,900.00	22,694,700.00	494,200.0	97.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,551,100.00	18,383,100.00	168,000.0	99.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,637,700.00	4,626,100.00	11,600.0	99.7
210205	Эрүүл мэндийн даатгал	46,377,900.00	46,318,200.00	59,700.0	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	697,976,300.00	697,976,292.00	8.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	22,437,400.00	22,437,400.00	0.0	100.0
210302	Түлш, халаалт	600,913,100.00	600,913,100.00	0.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	74,625,800.00	74,625,792.00	8.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	28,783,200.00	28,770,342.50	12,857.5	100.0
210401	Бичиг хэрэг	3,420,100.00	3,627,000.00	-206,900.0	106.0
210402	Тээвэр, шатахуун	3,049,200.00	3,049,200.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00	0.0	100.0
210404	Ном, хэвлэл	3,113,900.00	3,113,500.00	400.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	1,400,000.00	1,398,000.00	2,000.0	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,300,000.00	16,082,642.50	217,357.5	98.7
2105	Нормативт зардал	58,776,500.00	58,253,093.00	523,407.0	99.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,482,700.00	1,480,208.00	2,492.0	99.8
210502	Хоол, хүнс	34,413,800.00	33,901,365.00	512,435.0	98.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,880,000.00	22,871,520.00	8,480.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,900,000.00	67,854,672.00	45,328.0	99.9
210602	Тавилга	20,000,000.00	20,000,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	47,900,000.00	47,854,672.00	45,328.0	99.9
2107	Томиллолт, зочны зардал	72,000.00	72,000.00	0.0	100.0
210702	Дотоод албан томиллолт	72,000.00	72,000.00	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,454,200.00	3,448,300.00	5,900.0	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил	2,614,200.00	2,608,300.00	5,900.0	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.0	100.0

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93830300.00	93814510.00	15,790.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,830,000.00	38,830,000.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,000,300.00	54,984,510.00	15,790.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,671,200.00	54,316,557.00	2,354,643.0	95.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,671,200.00	54,316,557.00	2,354,643.0	95.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,005,400.00	51,652,975.00	2,352,425.0	95.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,665,800.00	2,663,582.00	2,218.0	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,052,701,400.00	4,049,742,803.49	2,958,596.5	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,323,725,100.00	3,320,766,511.49	2,958,588.5	99.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,323,725,100.00	3,320,766,511.49	2,958,588.5	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	718,976,300.00	718,976,292.00	8.0	
132001	Орон нутгийн төсвөөс	718,976,300.00	718,976,292.00	8.0	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	10,000,000.00	0.0	100.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,000,000.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	170.00	170.00	0.0	
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	
620002	Гүйцэтгэх ажилтан	124.00	124.00	0.0	
620003	Үйлчлэх ажилтан	45.00	45.00	0.0	
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	2,378.00	2,378.00	0.0	
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИ	2,378.00	2,378.00	0.0	
630001	Төрийн өмчит ЕБС	2,378.00	2,378.00	0.0	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	131756716.00	183,578,744.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131756716.00	183,578,744.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26043875.00	55,196,391.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26043875.00	55,196,391.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26043875.00	55,196,391.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75602297.00	128,382,353.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	75602297.00	128,382,353.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7892025.00	128,382,353.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	67710272.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	131756716.00	183578744.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,840,491.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97820816.00	128,382,353.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33935900.00	53,355,900.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн ба тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг захирал Ц.Алтангэрэл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурагчдын авьяас чадварыг хөгжүүлэх сонгон дугуйлан хичээллүүлэх
- Багш ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хөгжих бололцоогоор хангах.
- Эцэг эх олон нийтийн хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Багш нарын шилдэг туршлага, сургалтын тэргүүний арга зүй технологийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах
- Хүүхдийн өөрийн оролцооны байгууллагыг удирдах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,185,520.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 41,855.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 29,298.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 30,812.3 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,512,199.5 мянган төгрөгөөр буюу 76.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	199,611.9	240,780.1	41,168.1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	14,175.5	1,132.8	(13,042.8)
Урьдчилгаа	2.7	2.7	-
Бараа материал	185,433.6	239,644.5	54,210.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,374,913.3	10,845,944.7	8,471,031.4
Үндсэн хөрөнгө	3,265,871.2	11,999,463.0	8,733,591.8
Хуримтлагдсан элэгдэл	(890,957.9)	(1,153,518.3)	(262,560.4)
Нийт хөрөнгө	2,574,525.3	11,086,724.8	8,512,199.5
Өр төлбөр	319.4	1,716.4	1,397.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,574,205.9	11,085,008.4	8,510,802.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,574,525.3	11,086,724.8	8,512,199.5

Авлагын дансны үлдэгдэл 13,042.8 мянган төгрөгөөр буурсан нь 2020 оны жилийн эцэст хүлээж аваагүй хөрөнгийг авлагаар тусгасан бөгөөд тайлант онд тус хөрөнгийн хүлээн авч авлагыг хаасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 239,644.5 мянган төгрөг болж 54,210.9 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Боловсрол соёл урлагийн газраас 3,668.3 мянга, аймгийн Онцгой комиссоос Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 1,810.0 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан ба урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авалтаар 244,171.7 мянган төгрөгийн хөрөнгийг авч, 198,502.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,999,463.0 мянган төгрөг болж 8,733,591.8 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.06.21-ний өдрийн 81 дугаар тогтоолоор УТХО-аар баригдсан 8,660,858.9 мянган төгрөгийн анхны өртөг бүхий сургуулийн шинэ барилга, мөн өмнөх онд авлагаар тусгасан 9,950.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 95,793.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.06.21-ны өдрийн 80 дугаар тогтоолоор 90 нэр төрлийн 33,619.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,085,008.4 мянган төгрөг болж 8,510,008.4 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө худалдсаны гарз 50.0 мянга, тайлант үеийн үр дүн 8,510,802.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,211,220.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 6,211,220.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,491,411.7 мянган төгрөгөөр бууруулж, 3,719,808.7 мянган төгрөгөөр анх баталсан нь шинэ байр ашиглалтад орохтой холбоотойгоор холбогдох зардлуудыг нэмж төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээр санхүүжүүлэхээр 2021 оны 11 дүгээр сард тодотгон 4,052,701.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,323,725.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 718,976.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,323,725.1 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 718,976.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 4,049,742.8 мянган төгрөгийг зарцуулж, 2,958.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,049,742.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг 12.9 мянга, нормативд зардлыг 523.4 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 45.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил,

үйлчилгээний төлбөр хураамжийг 5.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 15.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 128,382.4 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 55,196.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 2020-2021 оны хичээлийн жилд нийт 170 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, нийт 82 бүлэг, 2986 сурагчтайгаас бага ангид 1140, дунд ангид 1126, ахлах ангид 695, албан бусаар 84 сурагч 2 бүлгээр суралцаж байгаа бөгөөд 2021 оны үйл ажиллагааны зардалд 4052.7 сая төгрөг батлагдсан байна

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 70 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 97.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 4,401,751.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 216,230.8 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, томилолт зочны зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

2021 оны төсвийг 3,719,808.7 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 332,892.7 мянган төгрөг нэмж баталснаас 3,323,725.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 718,976.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан.

Анх баталсан зардлаас өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 371,744.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 41,551.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 57,998.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлууд 53,500.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ч байр ашиглалттай холбоотой тогтмол

зардал 12,773.8 мянга, хангамж бараа материалын зардал 6,135.5 мянга, нормативт зардал 110,568.6 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 10,254,893.7 мянган төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байдлыг шалгахад хуулийн 6.4.5-д заасан орлого, зарлагын 74,839.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг тус тус хугацаа хоцроосон байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 3,719,808.7 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 332,892.7 мянган төгрөг нэмж баталснаас 3,323,725.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 718,976.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 710,750.1 мянган төгрөгөөр, тодотголоор 697,976.3 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 697,976.3 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 12,773.8 мянган төгрөг буюу 1.8 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 3,420.1 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 3,627.0 мянган төгрөг зарцуулсан нь дээрх тогтоолтой нийцэхгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28,103.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 5,552.2 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 732.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21,819.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Залруулга

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн ЗДТГ-ын НБХ-ээс жагсаалтаар ирүүлсэн 10 нэр төрлийн 2,759.0 мянган төгрөгийн өртөг бүхий спортын хэрэглэгдэхүүн, БСШУЯ-аас ирүүлсэн 1,793.2 мянган төгрөгийн өртөгтэй компьютерыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох газруудаас үнэ төлбөргүй ирсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланд залруулав.

2. Тайлант онд "Бумбат суурь" ХХК-руу хуучин сургуулийг нураах зураг төсвийн үнэ болох 1,000.0 мянган шилжүүлсэн ч авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зураг төсвийн үнэ 1.0 сая төгрөгийг авлагаар бүртгэж, санхүүгийн тайланд залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 2021.10.28-ны өдөр 660.0 мянган төгрөгийг ахмадын баярын үйл ажиллагаанд, томилолтын зардлаас 2021.06.23-ны өдөр 72,0 мянган төгрөгийг зориулалт бусаар олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар 732.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

1. Тайлант онд төсөвт төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлаас зохицуулалт хийлгэн 41,050 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 21,819.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол " Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээ"-ний 1.4 “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон

нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

2. Тус байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг тулгахад анх 3,719,808.7 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021 оны 11 дүгээр сард 332,892.7 мянга буюу 8.9 хувиар өсгөж 4,052,701.4 мянган төгрөгөөр баталсан байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,773.8 мянга буюу 1.8 хувиар хэмнэсэн ч, бичиг хэргийн зардлыг бууруулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.6 “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” 1.9 “Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, бичиг хэрэг болон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан орлого, зарлагын 74,839.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг тус тус хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх зөвлөмжийг өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори Номундалай цогцолбор сургууль	6	28,103.7	2	5552.2	1	732.0	0	0	3	21,819.5

_____оОо_____